



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ХАНХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/20

Ханх сум

**Газар зүйн нэрийн салбар зөвлөл
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 40.2.1, 43 дугаар зүйлийн 43.1, Геодези, зураг зүйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8.1, 5.8.2, 5.8.4, Монгол улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 186 дугаар зарлиг, Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолыг тус тус үндэслэн захирамжлах нь:

1.Тус сумын "Газар зүйн нэрийн салбар зөвлөл"-ийг дараах бүрэлдэхүүнтэйгээр баталсугай.

Салбар зөвлөлийн дарга:

Гишүүд:

Б.Баттүвшин (Сумын Засаг даргын орлогч)

К.Одгэрэл (Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга)

Б.Баасансүрэн (Тамгын Газрын дарга)

Ж.Батцэцэг (Санхүү албаны дарга)

М.Жавзан (Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Ш.Отгонжаргал (1-р багийн Засаг дарга)

Б.Анхбаяр (2-р багийн Засаг дарга)

Э.Мөнхжаргал (3-р багийн Засаг дарга)

Б.Бямбабаяр (4-р багийн Засаг дарга)

Т.Нямцэцэг (Газрын даамал)

Нарийн бичгийн дарга:

2."Газар зүйн нэрийн салбар зөвлөл" байгуулсантай холбогдуулан "Газар зүйн нэрийн хээрийн тодруулалтыг сумын хэмжээнд хийх" ажлыг зохион байгуулах, "Газар зүйн нэрийн мэдээллийн сан" бүрдүүлэх, шинээр өгөх, өөрчлөх газар зүйн нэрийн саналыг хэлэлцэн аймгийн "Газар зүйн нэрийн салбар зөвлөл"-д хүргүүлэх болон бусад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тухай бүрд шийдвэрлүүлэн ажиллахыг салбар зөвлөлийн дарга нарийн бичиг, гишүүдэд үүрэг болгосугай.

3.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн (О.Золзаяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Л.ДАВААБАЯР

